



**ДС ББ-ын дээд удирдлагын шударга, хараат бус
байдлыг хангах бодлого, мэдэгдэл**

DC R-02 F-01

Бидэнд итгэх үйлчлүүлэгчдийн ИТГЭХ ИТГЭЛ бол манай баталгаажуулалтын байгууллагын хамгийн том үнэт зүйл юм.

Бид менежментийн тогтолцооны баталгаажуулалтын үйл ажиллагаанд үнэн зөв, шударга, хараат бус байдлыг хангах, үүний тулд бид ашиг сонирхлын зөрчил болон менежментийн тогтолцоогоо зөв удирдаж, баримтжуулалтын үйл ажиллагааны бодит байдлыг хангах зорилго тавьдаг.

ДС ББ-ын гүйцэтгэх захирал нь үйлчлүүлэгчийнхээ итгэлцэл болон хараат бус байдлыг хангахын тулд дараах зарчимуудыг баримтлан ажиллахыг нийт ажилтнуудад үүрэг болгож байна. Үүнд:

- Ёс зүйн дүрмийг чанд баримтлан үйлчилгээ үзүүлэх;
- Бүх талуудад шударга, бодит, тэгш үйлчилгээ үзүүлэх;
- Нууцлалын бодлого, дүрмийг бүрэн мөрдөж ажиллах;
- Нийгмийн хариуцлагын хүрээнд үйл ажиллагаа явуулах;
- Шударга, хараат бус байдлыг алдагдуулахгүйгээр үйлчилгээ үзүүлэх;
- Үйл ажиллагаандаа мэргэжлийн өндөр хариуцлага хүлээх;
- Үйл ажиллагаандаа холбогдох бүх талуудыг шударгаар төлөөлөх;
- Хангалттай чадамж, ур чадвартай салбарт үйлчилгээ үзүүлэх;
- Мэргэжлийн ёс зүйд харш аливаа үйлдэл, авлига, дарамт, нөлөөллөөс ангид байх;
- Хэрэглэгчийн гомдлыг хариуцлагатайгаар, мэдрэмжтэй шийдвэрлэх;
- Үйлчлүүлэгч байгууллагын менежментийн тогтолцоонд дотоод аудит хийхгүй;
- Баталгаажуулалтын үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудыг баталгаажуулахгүй;
- Баталгаажуулалтын шийдвэрийг гаргахдаа бодит нотолгоонд тулгуурлан, тодорхой, ойлгомжтой хэлбэрээр илэрхийлнэ;
- Манай байгууллага баталгаажуулалтын шийдвэр гаргах эрхийг гуравдагч этгээдэд шилжүүлэхгүй;
- Үйлчлүүлэгчийн аудит болон баталгаажуулалтын төлвийн талаарх мэдээллийг зохих журмаар нээлттэй, зөвшөөрөгдсөн хэлбэрээр хүргэнэ;
- Аливаа ажилтан нь албан тушаал, байр сууриа хувийн ашиг олох зорилгоор ашиглахгүй;
- Менежментийн тогтолцооны талаар зөвлөгөө өгөх, чиглүүлэх үйл ажиллагаа явуулахгүй;
- Баталгаажуулалтын явцад хараат бус байдалд эрсдэл үүссэн тохиолдолд баталгаажуулалт олгохгүй;

- Аудитын явцад итгэлцэл эсвэл хувийн харилцаанд үндэслэн дүгнэлт гаргахгүй;
- Ажилтан, үйлчлүүлэгч болон нийлүүлэгчид ямар нэгэн дарамт үүсгэх бодлого хэрэгжүүлэхгүй;
- Шударга, хараат бус байдалд нөлөөлж болзошгүй эрсдэлийн үнэлгээг тогтмол хийж, арилгах эсвэл бууруулахад шаардлагатай арга хэмжээг авдаг байх зэрэг болно.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Б.ЭРКИГҮЛ

Огноо: 2025.12.21